



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/282

Булган сум

Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа
явуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Засгийн газрын “Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах байршил, хэмжээ, зориулалтыг батлах тухай” 2026 оны 45 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаалаар баталсан “Газар эзэмшүүлэх дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлалыг шинэчлэн батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт газар эзэмшүүлэх дуудлага худалдааны журмаар олгох газрын байршил, хэмжээ, зориулалт, анхны үнийг хавсралтаар баталсугай.

2.Газрын дуудлага худалдааг цахим хэлбэрээр 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 10:00 цагт товлож, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд олон нийтэд зарлан зохион байгуулан, явуулахыг газрын дуудлага худалдааны ажлын хэсэг (С.Наранбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010415

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 22-ний өдрийн
А/282 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХ ГАЗРЫН
БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, АНХНЫ ҮНЭ

| д/д | Сум | Газрын байршил | Газрын зориулалт | Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар | Газрын хэмжээ м ² | Дуудлага худалдааны анхны үнэ (төгрөг) |
|-----|------------|--|--|-----------------------------------|------------------------------|--|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Булган сум | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 6-р баг Залуус-18 1801а тоот | 4937675 | 970 | 5820000 |
| 2 | | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 6-р баг Залуус-18 1806е тоот | 4950906 | 81 | 486000 |
| 3 | | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 5-р баг Анхдагчдын өргөн чөлөө-1 1266 тоот | 4996395 | 519 | 3114000 |
| 4 | | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 6-р баг Залуус-18 1806д тоот | 4996397 | 392 | 2352000 |
| 5 | Дүн | | | | 1962 | 11772000 |

--о00о--